

**Монгол улсын Төрийн соёрхолт, Сүхбаатарын одонт,
Шинжлэх ухааны доктор, профессор, “Ахмад хүндэт геологич”
Жамбын Бямба”-ын геологийн салбарт оруулсан хувь нэмэр
өгөөжийн тухай тэмдэглэл оршивой**

Г.Сугаржав

Геологи, уул уурхайн салбарын ахмадын холбооны тэргүүн

Ж.Бямба нь 1940 онд Баянхонгор аймгийн Богд сумын нутагт төржээ. Яс үндэс халх. Ам бүл 2. Тэрбээр 1949-1959 онд Баянхонгорт бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1959-1965 онд Москва хотод геологи-хайгуулын дээд сургуульд суралцаж уулын инженер геологчийн мэргэжилтэй болсон. 1972 онд “Хойд Монголын рифей-кембрийн стрүктүр-фацын бүсүүд ба тэдгээрийн фосфорит агууламж” сэдвээр геологи-минералогийн ухааны дэд эрдэмтний, 1991 онд “Монголын хожуу протерозой-түрүү палеозойн тектоникийн хөгжил ба эртний фосфорит үүссэн геологийн нөхцөл” сэдвээр геологи-минералогийн шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан. 1994 онд Японд Жайка-гийн шугамаар геологийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлсэн.

Ж.Бямба нь 1965-1968, 1972-1976 онд геологийн салбарт дагалдан геологч, хэлтсийн дарга, яамны ерөнхий геологч, Геологи-Шинжилгээний газрын орлогч дарга, 1982-1989 онд Геологи-уул уурхайн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, секторын эрхлэгч, 1992-1994 онд Монголын геологийн албаны ерөнхий захирал, 1968-1972 онд ЭЗХТЗ-ийн нарийн бичгийн дарга нарын газар зөвлөх, 1976-1982 онд ЭЗХТЗ-ийн БНМАУ дахь Олон Улсын Геологийн Экспедицийн дарга, 1989-1992 онд БНМАУ-аас ЭЗХТЗ-д суугаа байнгын төлөөлөгчийн орлогчоор 1992-1994 онд Монголын геологийн албаны

ерөнхий захирал, 1994-1997 онд Заамарт алтны үйлдвэрийн даргаар тус тус ажилласан байна. Ж.Бямба нь МУИС, ШУТИС, Политехникумд геологийн мэргэжлээр 20 гаруй жил цагаар болон багшийн орон тоон дээр ажилаж ирсэн ба өдөөгөө 2014 оноос Геологийн судалгааны төвд бүлгийн ахлагч, зөвлөх зэрэг ажлыг хийж байна.

ЭЗХТЗ-д ажилаж байхдаа Монголд Олон Улсын геологийн экспедицийг гишүүн орнуудын буцалтгүй тусламжаар зохион байгуулах тухай анхны саналыг тэрбээр МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын газар, Сайд нарын Зөвлөлд тавьж уг асуудлыг дэмжүүлэн, улмаар зохион байгуулан эхлүүлж 5 жил удирдсан. Уг экспедицийн шугамаар нийтдээ 1 тэрбум 200 гаруй сая шилжих рублийн буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар 100 гаруй мян.км кв талбайд иж бүрэн геологийн судалгаа үйлдвэрлэлийн ажлыг Дорнод Монгол, Өмнөд говьд хийж, Төв ба Баруун Монголд 102-р уртрагаас баруун тийш эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн. Түүнээс гадна 20 орчим сая шилжих рублийн хөрөнгөөр экспедицийн контор, үйлдвэрлэлийн иж бүрэн баазыг орон сууцны хамт Толгойтод барьж ашиглалтад оруулжээ. Уг ажлын үр дүнд Өндөр Цагааны вольфрам-молибдений, Мөнгөн Өндөрийн мөнгө-полиметаллын, Хоёр зотлигийн алтны, Цагаан чулуутын молибдений, Хөлийн холбоогийн хайлуур жоншны, Баянмөнх толгойн

титан-магнетитын ордуудыг илрүүлж одоо ашиглахад бэлэн болжээ. Сэрвэнгийн хайлуур жонш, Тугалагатайн нурууны хар тугалганы ордуудад гүйцээх хайгуул хийж ашиглалтад бэлтгэжээ. Одоо уг экспедицийн суурийн дээр алт олборлолт, газар тариалан, аялал жуулчлал, геологийн судалгаа, худалдаа үйлчилгээний чиглэлээр “Гурван гол”, “Гачуурт”, “Нүхт”, “Скарн” гэдэг нэртэй хэд хэдэн хувьцаат компани үр бүтээлтэй ажиллаж байна.

1972-1993 онуудад Монгол даяар цугларсан геологи, ашигт малтмалын бүх материалыг тухайн үеийн шинжлэх ухааны түвшинд эмхэтгэсэн Монголын анхны 1:1000000 масштабтай геологийн ба Монголын структур-формацын анхны зургууд болон Монголын нутаг дэвсгэрт тархсан бүх ашигт малтмалын прогноз-зүй тогтолын мөн 1:1000000 масштабтай 30 орчим зураг, тайлбар бичгийн хамт боловсруулах ажлыг “Гео зураг” хэмээх төслийн хүрээнд биечлэн удирдаж өөрийн биеэр оролцож дуусгасан нь одоогийн зах зээлийн үеийн геологийн судалгааны ойрын ба хэтийн чиглэлийг тогтооход чухал баримтууд болж байна. Ж.Бямба нь эдгээр зургуудын зохиогч, ерөнхий ба орлогч редактораар ажиллаж байсан.

Ж.Бямба нь Монголын геологийн тогтоцын талаар эрдэм шинжилгээний өгүүлэл, хураангуй, редакторласан ажил, зохиосон зураг нийтдээ 160 гаруйг туурвисны зарим нь Англи, Герман, Хятад, Чех, Польш, Болгар, Орос, Монгол хэл дээр нийтлэгдсэн. Эдгээр бүтээлүүдэд гадаадын олон эрдэмтэн судлаачид ишлэл хийж байсан байна (Бүтээлийн ба ишлэлийн жагсаалтыг хавсаргав).

Профессор Ж.Бямба үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний ажлын хажуугаар мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд ихээхэн анхаарч МУИС, ШУТИС, Политехникумын оюутнуудад “Эрэл хайгуул”, “Геофизик”, “Монголын геологи”, “Тивүүдийн геологи”, “Далайн геологи”, “Монголын стратиграфи”, “Ази, Монголын

геологи”, “Геотектоник”, “Геодинамик” зэрэг хичээлүүдийг зааж 1998 онд дэд профессорын цол хүртсэн ба тэрбээр МУИС-д 2018 он хүртэл цагийн ба зөвлөх профессор үргэлжилэн ажилласан. Ж.Бямба нь 2011 онд ШУТИС-ийн хүндэт профессор цолоор шагнагдажээ. Энэ завсар сургалтад зориулан “Далайн геологийн тойм”, “Стратиграфи”, “Тектоникийн үндэс”, “Геотектоник”, “Стратиграфийн үндэс” зэрэг 10 орчим сурах бичиг бичжээ. Энэ сурах бичгүүд нь 2-3 удаа хэвлэгдсэн, монгол хэл дээр гарсан анхны сурах бичгүүд юм.

“Монголын эртний структур ба фосфорит агууламж” хэмээх томоохон нэг сэдэвт зохиол нь 1997 онд МУИС-ийн шилдэг бүтээлээр шалгарч Японы Крияамагийн 1-р зэргийн шагнал хүртэж байжээ. Үүний үндсэн дээр Монголын нутагт фосфоритын судалгааны ажил явуулах үе шат, дэс дарааллыг тогтоосон байна. Энэхүү прогнозын үндсэн дээр Хөвсгөлийн савын фосфоритын нөөцийг Ж.Бямба 3 тэрбум тонн хүртэл үнэлсэн ба 1972 онд Мөрөн хотын дүүрэгт фосфоритын орд нээгдэх шинжлэх ухааны прогноз хийсэн нь энэ дүүрэгт Бүрэнхааны фосфоритын орд нээгдсэнээр батлагдсан. Энд жилд дунджаар 3 сая тонн хүдэр олборлоход олон арван жилийн нөөцөөр хангахад хүрэлцээтэй юм. Тэгээд ч энэ ордыг олборлосноор Монгол улсад химийн аж үйлдвэрийн үндэс суурь тавигдаж фосфоритын бордоо үйлдвэрлэж хөрсний чанар, бүтцийг сайжруулан өндөр ургац авах боломжтой бөгөөд эдийн засгийн хувьд газар тариалангийн бүсийн хөрсний чанарыг сайжруулан улмаар ган зуд болдог өнөө үед мал, гахай, шувууны бордооны чанарыг үндсээр нь сайжруулах нэн чухал үр ашигтай юм.

Ж.Бямба нь Монголын анхны геологийн (1993 он) ба анхны Структур-формацын (1993 он) 1:1000000 масштабын, “Төв, Дорнод Монголын” (1990 он), “Хойд Монголын” 1:500000 масштабын зургуудыг зохиоход оролцож орос хэл

дээр хэвлэгдсэн “Өмнөд Сибир, Хойд Монголын” геологийн зургийг хянахад гишүүнээр оролцож, Монголын тектоникийн 1:2500000 масштабын сургалтын анхны зураг зохиосон байна. 2010 онд “Монголын геодинамик”-ийн мөн анхны зургийг (1:3000000 масштабтай) зохиохын хамт 1999 онд “Монголын геологи”-ийн 1:1000000 масштабтай зургийн орлогч эрхлэгчээр ажиллажээ. Тэрбээр “Зүүн-хойд Азийн тектоник, металлоген ба эрдэс баялаг” олон улсын судалгааны төсөлд оролцжээ. Ж.Бямба нь 2014 оноос эхлэн “Хойд-Төв-Зүүн Азийн гүний тогтоц ба металлогени” хэмээх олон улсын сэдэвт судалгааны ажилд оролцож ирсэн ба одоо Орос, Хятад, Солонгос, Казакстан, Монгол гэсэн 5 улсын хамтарсан судалгааны төслийн Монголын аккрец-коллизын ба рифт-плюмийн 1:5000000 масштабтай зураг зохиох ажлыг удирдан ажиллаад дуусгасан байна.

Одоо тэрбээр Монгол, Орос, Хятад, Казакстаны хил залгаа нутаг дэвсгэрийн Алтайн уулсын геологи, ашигт малтмалын зураг зохиох ажилд зөвлөхөөр ажиллаж байна.

Доктор Ж.Бямба нь “Монголын геологи, ашигт малтмал” хэмээх 365 хэвлэлийн хуудас бүхий (Стратиграфи, Палеонтологи, Интрузив чулуулаг, Литосферийн плитийн тектоник, Шатах ашигт малтмал, Метал ашигт малтмал, Метал бус ашигт малтмал, гидрогеологи) 8 боть цуврал эрдэм шинжилгээний бүтээл туурвих ажлыг анх санаачлан ерөнхий эрхлэгчээр нь ажиллан “Стратиграфи”, “Литосферийн плитийн тектоник”, “Метал бус ашигт малтмал” зэрэг ботниудыг бичихэд оролцжээ. Уг цувралыг бүтээхэд 53 эрдэмтэн геологчид оролцсон ба Монгол улсын оюуны томоохон бүтээл болсноор 2018 онд бусад 5 эрдэмтэд (Р.Барсболд, Ж.Лхамсүрэн, Н.Жадамба, О.Гэрэл, С.Алтангэрэл) нарын хамт МУ-ын “Төрийн соёрхол” хүртсэн болно. Энэхүү цуврал бүтээлийн 40 иж бүрдлийг ШУТИС-д, 30 иж бүрдлийг МУИС-д, тодорхой хувийг Ховдын Их сургууль, Дарханы коллежид

тус тус сургалтанд зориулан бэлэглэсэн нь үндэсний хэл дээр сурах бичиг байхгүй байгаа одоо үед геологи уул уурхайн салбарын оюутны ширээний ном болж байна.

Ж.Бямба нь Монгол, Зөвлөлт, Чехословак улсуудын геологийн салбарын тэргүүний геологч, мөн Монголын урчуудын эвлэлийн, Монгол улсын шинжлэх ухааны, Ардын боловсорлын тэргүүний ажилтан цол, тэмдэгээр тус тус шагнагджээ. Ж.Бямба МУ-ын “Төрийн соёрхол”-той ба Сүхбаатарын одон, Ардын Хувьсгалын 50, 60, 80 жилийн ойн, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн ба ЭЗХТЗ-ийн 25 жилийн ойн медалиудаар тус тус шагнагдаж байсан. Мөн Ж.Бямба нь ард түмний Шинжлэх ухааны гавъяат ажилтан цолоор шагнагджээ.

Ж.Бямба нь сүүлийн жилүүдэд (2008-2015 онд) Монгол Улсын 4 дэх Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 1991 онд гаргасан 115 дугаар зарлиг болон түүнийг хэрэгжүүлэхээр Засгийн газраас гаргасан заавар зөвлөмжийн дагуу Баянхонгор аймгийн Богд сумын 1000 гаруй иргэдийн бүгд 95 овгийн угийн 9 үеийн 250-300 жилийн бичгийг сурвалжлан бүтээсэн нь дээрх зарлигийг хэрэгжүүлэхээр улсын хэмжээнд хийж байгаа ажлуудаас анхных нь боллоо. Энэ нь Богд сумын ардуудын улмаар Баянхонгор аймгийн бүх сумдын угийн бичгийг хөтлөх гол лавлах үндэс суурь нь болж байна. Энэ чиглэлээр тэрбээр сургалт, семинарын ажлыг Монголын Угийн бичгийн холбоотой хамтран Баянхонгор аймгийн хэмжээнд зохион байгуулахад оролцжээ. Түүгээр ч барахгүй Ж.Бямбын санаачлан хийсэн энэхүү загварын дагуу улсын хэмжээний бүх 21 аймаг, 8 дүүргийн угийн бичгийг хийлгэхээр Монголын Ураг, удам, уламжлалын холбооны шугамаар төлөвлөөд байна. Энэ угийн бичгийн судалгааны ажил нь нэг нутгийнхан бараг сүүлийн 300 жилийн гарал үүсэл, удам угсаагаа мэдээд зогсохгүй, монгол хүмүүсийн цус ойртохгүй,

удмын өвчин зовлонгүй, эрүүл саруул явахын үндэс болно. Түүгээр ч барахгүй энэ ажил нь монгол үндэстний хойчийн ирээдүйг цэвэр ариун байлгаж, улс орноо хөгжүүлэхэд баттай үндэс суурь болох юм.

Ж.Бямба нь Монгол Улсад анх удаа байгалийн аяллыг санаачлан 1980 онд 100 дугаар уртрагаар байгалийн (царам, тайга, ой, ойт-хээр, хээртал, говь-цөлийн босоо) ба хэвтээ бүслүүрийг огтлон аялахдаа биологч, газар зүйч-бэлчээр судлаач, экологч-гэрэл зурагчин, геологч, зохиолч нарын хамт 4000 км аялж Хөвсгөл, Архангай, Баянхонгор аймгуудын нутагт байгалийн аялал зохиох маршрут гарган зөвлөмж бүхий тайланг тухайн үеийн Биеийн тамир, спортын хороонд шилжүүлж байжээ.

Ж.Бямба багшийг та бүхэн сайн таньж мэддэг боловч :-Энэ хүн юубүтээсэн,яаж ажил амьдарч байсан талаар Монголын ард түмэнд тодорхой болгохын үүднээс: Ж.Сумъяа нарын "Мянганы босго алхсан Монгол геологичид"(цаашид МБАМГ гэх).2009он, Д.Санжаадорж нарын "Монголын геологийн есөн эрхэм"(цаашид МГЕЭ гэх).2014он, Ө.Жамьяндоржийн "Чулуу судлаач чухал хүмүүс"(цаашид ЧСЧХ гэх).2019он зэрэг Ж.Бямба багштай холбоотой олон олон ном товхимолууд ялангуяа 2017 онд надад бэлэглэсэн "Хоёр үнэний хооронд" 3 боть номыг А-гаас Я хүртэл нь нарийвчлан судалсны хүчэнд доорхи дүр төрх бий болсныг та бүхэнд толилуулахдаа туйлын их таатай байнаа...

Үүнд: 1. Ж.Бямба нь " МОНГОЛ УЛС"-ын хөгжилд ихээхэн үүрэг гүйцэтгэж ирсэн "Геологи гэдэг том айл"-ын халуун бүлд багтан ажиллаж, хөдөлмөрлөж, зам мөрөө тодоос тод үлдээсэн азтай хүмүүсийн бодит төлөөлөл "Үндсэн мэргэжилдээ төдийгүй ШУ-ны олон салбар чиглэлээр боловсорч мэргэшсэн бас бичих ур чадварыг хэнээс ч илүү эзэмшсэн нэгэн болох нь уйгагүй хөдөлмөрч,шинийг эрэлхийгч,эх орон

ард түмнээ гэсэн чин сэтгэлтэй, унасан газар, угаасан ус газар шороондоо хязгааргүй хайртай түүнийхээ төлөө мятаршгүй тэмцэгч,эх орныхоо Тухайлбал: Геологийн шинжлэх ухааныг улс орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө зориулан эрдэм мэдлэг, эрч хүч хөдөлмөрөө үл хайрлан ажиллаж байсан өнөөдөр ч ажилласаар байгаа нүүдлийн иргэншилтэй ядуу малчны хүү байснаа сургууль номонд суралцан суурин иргэншилд шилжин эгэл нэгэн дундаж сэхээтний амьдарлаар хорвоог туулж яваа түүнчлэн өөрийнх нь хэлснээр: "Монголын геологичдын өсч өндийсөн, хөгжиж дэвжсэн түүхийн "ТОМ БАРИЛГА"-д нэмэрлэсэн нэгэн тоосго юм "байнаа.(ХҮХ- I,II,III ботиуд)

2.Үхэлтэй өрсөлдөнхөн " Амьд явах сайхан боломж"-ийг ашиглан: Ж.Бямбын "Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт ба ишлэл" 2020 номноос миний биеэ түүвэрлэснээр: Нэг сэдэвт зохиол-19, сурах бичиг-7, толь бичиг-3, эрдэм шинжилгээний өгүүлэл-130, эрхэлсэн зохиолууд-17, эрхэлсэн ба зохиоход оролцсон зургууд-18, үйлдвэрлэл-эрдэм шинжилгээний тайлан-4, танин мэдэхүй-сурталчилгааны товхимол ба өгүүлэг-9, эрдэм шинжилгээний гол ишлэлүүд-9 мөн удирдан хамгаалуулсан магиструуд-7, шүүмж бичсэн докторын ажил-4, зөвлөхөөр ажилласан докторын ажил-2 болон эрдэм шинжилгээний нэр бүхий ишлэлүүд-412-той ба "Монголын геологи ба ашигт малтмал" —Стратиграфи-I боть-№5434, "Монголын геологи ба ашигт малтмал" —метал бус ашигт малтмал-VII боть-№5509, "Монголын геологи ба ашигт малтмал" —Литосферийн плитийн тектоник -IV боть-№5512 тоот зохиогчийн эрхийн гэрчилгээтэй болж уран сайхан, танин мэдэхүйн намтарчилсан тууж "Хоёр үнэний хооронд" 3 боть ном мөн "Литосферийн плитийн тектоник", "Монголын геодинамик ба ураны металлогени" ба олон улсын төслийн хэмжээнд Монголд анх удаа зохиосон Монголын аккрец-

коллизын ба рифт-плюмын 1:500 000 масштабын зургууд ба тайлбар бичгүүд, “Монгол орны эрдэс баялаг, түүний дэлхийн зах зээлийн байдал ба улс орны тусгаар тогтнол” (хамтран зохиогч Б.Батхишиг), “Геодинамикийн сэргээн босголтын үндэс ба Монголын тектоникийн дүүрэгчлэл” (хамтран зохиогч Б.Батхишиг, Б.Мөнхцэнгэл) зэрэг сүүлийн үед туурвисан геологийн онол практикийн бүтээлүүд нь “Геологийн шинжлэх ухаанд гарч байгаа Хавтант тектоник ба түүн дээр суурилсан геодинамик аргачлалаар Монголд геологийн судалгааны ажил явуулах болон эрдэс баялагийн ордыг шинээр онолын үндэстэй илрүүлэх боломжийг урьдчилан таамаглах үндэс суурь нь болж байгаа юм. Мөн түүнчлэн мэргэжлийн биш хүмүүст эрдэс баялгийн тухай, нөөц, орд, хортой ба ашигтай бодисын агуулга, экспорт, импортын үнийн хэлбэлзэл зэргийг өгч, улс орны үйлдвэрлэх хүчний байршил ба дэд бүтцийг төлөвлөхдөө чухам юунд анхаарах болон шинээр татаж болох дэд бүтцийн тухай санал дэвшүүлж, улс орны тусгаар тогтнол чухам юугаар тодорхойлогдох талаар үзэл бодлоо илэрхийлжээ.

3. Ж.Бямба бол МАХНамын хоёр их хурал(17 ба 20)-д оролцон үзэл бодол санаа оноогоо “Намын их хурлын индэр дээр”-ээс илэрхийлж мөн 1992 оны УИХ-ын сонгуульд Баянхонгор аймгийн 3 дугаар тойрогт МУ-ын ИХХУРЛЫН ГИШҮҮН-ээр сонгогдохоор нэр дэвшиж асан улс төр нийгмийн идэвхи сайтай эх оронч хүн гэдэг нь “Эх орон гэдэг бол Монголчууд бидний тухайлбал Бямба миний болон миний үр хүүхэд; удамынхны сэтгэл-зүрхэнд үүрд мөнхөд орших ганцхан дэлхийн “АЛТАНГАДАС” хэмээн зүйрлэж буй миний Монгол, миний төрсөн нутаг мөнөөс мөн болой” гэж товьёолсноор нотлогдох авай. Түүх алсарах тусам бүдгэрчдэг бол “Хоёр үнэний хооронд” номоороо өөрийгөө мөнхлөн, бүтээх тусмаа өөрөө өөрийнхөө дүр төрхийг улам ихээр тодруулсан эгэл хүн юм.

Монголын жирийн иргэний туулсан амьдралын замнал зөвхөн хувь хүний намтар төдий бус улс орны нийгмийн олон салаа мөчиртэй нэгэн үндэс байдаг ажээ. “Монголын эгэл жирийн малчны хөвүүн эрдмийн дөрөө дөрөөлсний үрээр олон сайн багш, сайхан нөхдийн ивээлээр, улс эх орныхоо буян хишгээр үзэсгэлэн төгөлдөр нутагаараа хөндпөн гулд явж эрдэнэсийн эрэл хайгуулд мордон шинжилгээ судалгаа хийсэн төдийгүй энэхүү замбуулангийн өрнө, дорнын хэдэн арван оронд хөл тавьж, ямар өндөрлөгт хүрч болохыг, Монголын нийгмийн ээдрээт цаг үед хүний хувь заяа хэрхэдгийг бас эхийн хэвлийгээс бус эмнэлгийн орноо шинэ хүн болон сэргэж,” Амьдралын алтан аяганаас рашаан хүртэх” хувь тохоосон тэргүүтнийг нүдээр үзэж, чихээр сонссон мэт мэдрэх болно. Бямбыг таньдаг ч бай, эс таньдаг ч байг энэхүү уран сайхан, танин мэдэхүйн намтарчилсан туужийг уншиж “Хоёр үнэний хооронд” 3 боть номоор зорчихуй: Монголын нүүдэлчин удмын сэхээтний баримттай уран сайхны намтар таны өмнө бүрнээ дэлгэгдэх нь эргэлзээгүй. (ХҮХ-I боть-Хэл бичгийн ШУ-ны доктор, профессор Дожоогийн Цэдэв.)

Ж.Бямба багшийг зөвхөн плиттектоникийн чиглэлийн судалгаа түлхүү хийж, “далайн геологи”-оор өвчилсөн геологич хэмээх нь үнэнд нийцэхгүй агаад уран зураг цуглуулагч, урлаг сонирхон судлаач, гэрэл зураг сонирхогч, Асралтхайрхан, Мөнххайрхан уулын оройгоос Монголоо тольдсон уулчин, аливаа шинэ зүйлийг санаачлан түүчээлэгч хэмээвэл олон талын мэдлэг, зохион байгуулах авъяас чадвар, эрдэм судлалын ажил бүтээлийг ундруулагч гэх нь ёс зүйд бүрэн нийцмөй. Одоо судалгааны явцад Бямба багшийн талаар бусад хүмүүстэй уулзан ярилцаж тэдний сэтгэгдэлийг цуглуулан авсан материалаа танилцай. Үүнд:

1. Ч.Хурц (МУ-ын Хөдөлмөрийн баатар, Геологи-эрдэс баялгийн ухааны доктор, Ph.D) ГУУСАХХолбооны Г.Сугаржавын бэлтгэсэн материалтай танилцлаа. 1. Ж.Бямба нь 1972 онд “Хойд Монголын рифей-кембрийн бүтэц-фацын бүсүүд ба фосфорит агууламж” сэдвээр дэд эрдэмтний мөн 1991 онд “Монголын хожуу протерозой-түрүү палеозойн тектоникийн хөгжил ба эртний фосфорит үүссэн геологийн нөхцөл” сэдвээр Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалан Хөвсгөл аймгийн Мөрөнгийн дүүрэгт фосфоритын ордууд нээгдэх хэтийн төлөв 3 тэрбум тонн гэж магдалсан /тогтоосоноор/-аар Монгол орны төдийгүй өөрийн нутагтаа фосфоритын нөөцгүй Орос, Хятадын зэргэлдээ дүүргүүдийн фосфорын бордоогоор он удаан хугацаагаар хангах нөөц бүхий Бүрэн хааны 100 сая орчим тонн хүдрийн нөөцтэй **ФОСФОРИТЫН** орд илрэн ашиглалтанд бэлтгэгдснээр геологийн ШУ-ны онол практикаар бүрэн батлагдсан бөгөөд Ж.Бямбын багш “Литосфер” хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах В.А.Ильин “Чи дэд эрдэмтний ажилдаа Мөрөн хотын ойролцоо фосфоритын орд нээгдэх прогноз хийсэн. Чи яг 10-т буудсан шүү гэж ёжлоод, ийм прогнозыг бүхэл бүтэн хүрээлэн хийдэг юм даа” дүгнэсэнтэй дүйцэж байгаа юм.

2. Ж.Бямба бид нарын зохиосон “Монголын геологийн ба структур формац” —ын анхны 1:1 000 000 масштабтай 30 орчим зургууд нь дараа дараачийн геологийн агуулгатай зургуудын үндэс суурь болсноос гадна шинээр байгуулагдсан **ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ** геологийн судалгааг төлөвлөх ба явуулах гол лавлах материал болжээ.

Ж.Бямба нь 1968-1972 ба 1989-1992 онуудад Эдийн Засгийн Харилцан туслах Зөвлөл /хойшид ЭЗХТЗ/-ийн нарийн бичгийн дарга нарын газарт зөвлөх болон Монголоос суугаа байнгын төлөөлөгчийн орлогч даргаар ажиллан тус Зөвлөлийн мандан бадрах, татан буугдахыг

нүдээрээ үзэж биеэрээ оролцсон түүхэн хүнээс гадна ЭЗХТЗ-ийн цогцолбор хөтөлбөрийн хүрээнд Монголд анх удаа геологийн салбарт Олон Улсын Геологийн Экспедиц/ОУГЭ/-ийг байгуулах санааг сэдэж, 1976-1982 онуудад анхны даргаар нь томилогдон ажилласнаар *“Монголын геологийн судалгаанд олон улсын судалгааны арга аргачлал, техник тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх улмаар Монгол геологичдад эзэмшүүлэх, Үндэсний геологийн Экспедиц, ангиудад үлгэр дуурайлал болгох”* зэргээр ОЮУНЫ том **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** (барагцаалбал нийт :100 сая орчим доллар) хийснээр стратегийн ач холбогдолтой ордын жагсаалтанд орсон Цагаанчулуутын молибден, Мөнгөн-Өндөрийн мөнгө-цайрын, Өндөрцагааны гянтболд-цагаан тугалганы , Хэнтийн Хөлийн Холбоо, Дорноговь, Сүхбаатарын хайлуур жоншны болон Хоёр зотлогын алтны, Баянмөнх толгойн титан-төмрийн ордуудыг илрүүлж, хайгуул хийн ашиглалтанд бэлтгэсэн ба зарим нь эдийн засгийн эргэлтэнд орсон байна.

Энэ бүгдээс товчхон дүгнэхэд: Ж.Бямба нь ЭХУ-д суралцан /геологийн/ мэргэжил эзэмшсэн геологичдийн бодит төлөөлөл бөгөөд өөрийн ухамсарт бүхий л амьдарлаа Монголд геологийн салбарыг хөгжүүлэхийн төлөө зориулсан Монгол хүн ,Монгол геологичид өөрийгөө дайчлан хөгжүүлж хичээнгүйлэн зүтгэвээс тухайн салбарыг дэлхийн төвшинд аваачиж чадах оюуны өндөр чадавхитай гэдгийг олон түмнээ таниулсан “Алтан үеийн АХМАД эрдэмтэн-геологич” юм.

Ж.Бямба Sc.D-ын туурвисан мэргэжлийн маш өндөр түвшинд бэлтгэгдсэн ном зохиол сурах бичиг, эрдэм шинжилгээний арвин их бүтээлүүд нь залуу геологичдад гарын авлага, Монголын геологийн салбарт Эрдэнэт, Оюутолгой, Таван толгой шиг олон арван стратигегийн ордуудыг нээн, илрүүлэх геологийн онолын суурь материал болж байгаагаараа онцгой ач холбогдолтой юм.

Монголын геологийн албатай нас чацуу шахам 85 насыг наслаж буй Ж.Бямбын энгэр дээр “Хөдөлмөрийн баатар”-ын “Алтан соёмбо” гялалзаж байхын бэлэгтэй ерөөл дэвшүүлье.

2.Н.Жадамба (МУ-ын “Төрийн соёрхолт”, Геологи-эрдэс баялгийн шинжлэх ухааны доктор(Sc.D))

Ж.Бямбыг 1960-иад оны үед Москвагийн Геологи-хайгуулын дээд сургуулийн оюутан байх үеээс нь мэднээ.

Биеийн тамирчин, гоё бичдэг бас зурдаг ялангуяа хошин зурагтаа сайн. Москвагийн бүх музейтэй танилцсан хүндээ. Түүнээс гадна их гоё бүжиглэнээ (вальс, твист, чарстон гм). Вальсаараа хэд хэдэн тэмцээнд түрүүлж ч байсан юм даг. Ер нь л олон талын гоц авъяастай хүн дээ.

Орос хэлийг хурдан хугацаанд сурч, сайн эзэмшсэн. Шалгалтандаа унадаггүй голцуу онц дүн авдаг оюутан байлаа.

Төгсөж ирээдүйдвэрлэл дээр геологийн онолыг амьдрал шинжлэх ухаантай холбон ажилласан. Өөрийнхөө идэвхи санаачлагаар Монголд анх удаа СЭВ-ийн тусламжтайгаар Олон улсын геологийн экспедиц (ОУГЭ гэх)-ийг байгуулан анхных нь даргаар үр бүтээлтэй ажилласан.

Гэр бүлийн өндөр хүмүүжил, боловсролтой ялангуяа төрсөн нутаг устайгаа байнгын холбоо шүтэлцээтэй. Энэ нь Баянхонгор аймгийн Богд сумын 1000 гаруй иргэдийн бүгд 95 овгийн угийн 9 үеийн 250-300 жилийн бичгийг сурвалжлан бүтээж ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэхээр улсын хэмжээнд хийж байгаа ажлуудаас анхных нь болсноор илэрхийлэгдэнэ.

Ж.Бямбын “Бидний үеийнхний ухаан санаа ч бас зүгээр суухгүй, танин мэдэх улмаар мэдсэн сурснаа өөрийн биеээр хийх, ойлгож мэдсэнээ улам боловсронгуй болгох нь оюуны тийм тэмүүлэлтэй түүнчлэн хүн бүр амьдралыг бүрэн дүүрэн мэдэрч түүний хөгжилд чадах

чинээгээрээ оролцож амьдрах нь эцсийн эцэст хувь хүний ухамсартай хариуцлага гэдэг”-тэй миний санаа оноо нэгдэхээс гадна Ж.Бямбыг Их Богдын нурууны сүрлэг уулс, ус гол, нуур тал, онгон дагшин байгалаас эх ундаргатай байж болох оюун ухаан ген удам угсаатай ШУ-ны олон ДОКТОР төрсний нэгэн” МОНГОЛ УЛСЫН хөгжилд ихээхэн үүрэг гүйцэтгэж ирсэн “Геологи гэдэг том айл”-ын халуун бүлд багтан ажиллаж, хөдөлмөрлөж “”зам мөрөө тодоос тод үлдээсэн азтай хүмүүс”-ийн бодит төлөөлөл нэг гэж “Эрдэмтэн-геологич” гэж талархан дэмжиж байна.

3. Ж.Лхамсүрэн (Төрийн соёрхолт, Ардын багш, Геологи-минералогийн ШУ-ны доктор (ScD), профессор)

2018 онд бидний хэсэг эрдэмтэд “Төрийн соёрхол” хүртэснийхээ дараа манай Бямба ч “Хөдөлмөрийн баатар”-ын энтэй хүндээ гэж байсан. Манай Бямба 85 нас хүрч байнаа. Амьд сэрүүн дээр нь ахмад үеийн геологичдоо Төр засгаараа үнэлүүлэхгүй бол “Хоногийн тоогоор хорогдоод” байна шүү. Та нөхдийн ялангуяа “Алтан үеийн АХМАД геологичид”-ын энэ бахархууштай санал санаачлага бүрэн биелэлээ олоосой хэмээн чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

4. Д.Санжаадорж (Эрдэс баялагийн яамны дэд сайд асан, МУ-ын “Зөвлөх инженер геологич”)

Зөвхөн шинжлэх ухааны доктор геологич төдийгүй шинжлэх ухааны олон салбарын танин мэдэхүй, уран сайханы намтарчилсан дорвитой том бүтээл туурвисан, аялал жуулчлал, урлаг, уран зураг, гэрэл зураг, түүхийн судалгааны арвин мэдлэгтэй багш, зохион байгуулагч болохыг” Хоёр үнэний хооронд” номын редактор, профессор Д.Цэдэв абугай “Энэхүү бүтээл нь түүх, баримт, тэмдэглэл, дурсамж, бодрол, халил тэргүүтнийг нэгэн хайлш мэт цогцлуулснаар намтрын хүрээнээс хальж “намтарчилсан тууж” хэмээх төрлийн дүр төрхийг цогцлоохыг

эрмэлзэж санасандаа хүрчээ” гэсэн байна.

Ж.Бямба нь мэдлэг боловсрол эзэмшсэн геологич, эзэмшсэн мэргэжлээрээ эрдмийн зэрэг цолтой доктор профессор, мэргэжлийн чиглэлээр онол арга зүйн танин мэдэхүйн 10 гаруй томоохон бүтээл туурвисан мөн төдий тооны номыг нөхөдтэйгээ хамтран бичсэн бас дотоод гадаадын ном сэтгүүлүүдэд эрдэм судлалын 100 гаруй бүтээл хэвлүүлсэн. (МГЕЭ-200х...)

Ж.Бямба гуай өөрийнхөө хөдөлмөр, бүтээлээр өөрийгөө үнэлж сэтгэл дүүрэн явах нь том шагнал юм шүү... гэсэн бодолтой явдаг хүн.

5. А.Гүррагчаа (ЭГФЦЭкспедиц болон ОУГЭ-ийн дарга асан)

Би 1982 онд ОУГЭ-ийн даргын албыг Ж.Бямбаас авсан юм. Экспедицийн ерөнхий инженер М.Корим(Чех), Унгарын геологич Л.Бучи-Сабо нар Бямба даргатайгаа Хэнтий нурууны ноён оргил Асралт хайрхан(2180м), Ховдын Мөнххайрхан(4169м) уулын оргилд олон улсын авиралт хийж “” Мөнх цастай мөсөн оргилд нь Монгол төрийн далбааг мандуулж явсан”-ыг бахархан дуурсдагсан. Өөрийнхөө санаачлагаар бүтээн босгосон ОУГЭ-ээс ихээхэн сэтгэл дундаар явсан санагддаг юм. Их зүйлийг хийсэн байсныг Хурц сайд товчлон хэлсэн тул энд давхардуулаад яахав.

Монголын нэг том эрдэмтэн, сайн геологич Ж.Бямба бол ШУ-ны олон салбарт нэвтэрсэн төрмөл авъяас хичээл зүтгэлээрээ гэрэл зурагчин, уран зургыг сайн ойлгох төдийгүй урлаг судлал тэр дундаа уран зураг, уран баримлыг мэргэжлийн өндөр түвшинд задлан шинжилж үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай бүтээлч сэхээтэн гэдэгтэй та нөхөд санал нийлэх байхаа.

XX зуунд Монголын геологийг Ж.Бямба, Э.Барс(сайд асан) хоёр л авч явсан юм даа.

6. Ж.Сумъяа (Аж үйлдвэрийн гавъяат ажилтан, Ахмад хүндэт геологич)

Бямба доктор “Хойд тундрийн догшин ширүүн уур амьсгалтай, цас мөст өндөр уулст Якутад 2 жил хөл тавьж Монгол хүний тэсвэр хатуужлыг таниулсан ховорхон геологичийн нэг. Тиймдээ түүнд фосфорит агуулсан Монголынхоо Хөвсгөлийн Хорьдол сарьдагийг ул суурьтай судлах хувь тавилан оногдсон /МБАМГ/ бөгөөд энэ эрхэм “ГЕОЛОГИЧ”-той Монгол орныхоо хөдөө хээрийн аяны замд хэрэн сүлжилдэн явахдаа албаны байдлаар ихэрхэлгүй, юуг яаж хийх ёстойг сайн мэддэг аливаа асуудлыг газар дээр нь шийдэж хамгийн зөв замыг хамтран олдог байлаа”... (ХҮХ-II боть, 440х)

6. Ө.Жамъяндорж (МУ-ын “Зөвлөх инженер”, Ахмад хүндэт геологич)

Ж.Бямба нь “Монголын урьд кембрийн стратиграфи, тектоник хөгжил, фосфоритын хүдэржилт зэрэг тулгуур асуудлаар мэргэшсэн, ОУГЭ-ийн анхны дарга, нэртэй геологич, хамгийн олон тооны ном бүтээл туурвисан геологийн бичгийн хүн, бүтээлч эрдэмтэн”. Түүний ерөнхий редактораар эрхэлсэн “Монголын геологи, ашигт малтмал” 8 боть суурь бүтээлд 2018 онд “Төрийн соёрхол” олгогдсон. “Гавъяат” цол нь хэзээ юм бол доо... (ЧСЧХ-182х). гэсэн бодолтой явдаг даа...

7. Б.Банзрагч (МУ-ын “Зөвлөх геологич”, Ахмад хүндэт геологич)

Өдгөө үед Ихбогд нутгаас шинжлэх ухааны олон доктор төрсөн нь эндэхийн хүмүүсийн оюун ухаан, ген, удам угсааг ямар нэг хэмжээгээр залгамжлан улмаар Ихбогдын сүрлэг уулс, ус гол, нуур тал, онгон байгалиас эх ундаргатай бус уу хэмээн бодохын ялдамд “Хүмүүн гэгч байгалийн эх бүтээл” —ийн амьд баталгаа гэдгээр тайлбарлагдах ажээмуу...

Ж.Бямба абугай төрсөн нутгийнхаа Угийн бичгийг өвөг дээдсийн тухай хууч яриа, ном судар. Архивын баримт сэлтэнд тулгуурлан 90 гаруй овгийг 9 үеэр мөшгөн шалгаж бүтээжээ. Угийн

бичгийг хүн-байгаль хоёрын амин шүтэлцээ гэжээ...Нэг үгээр хэлбэл “Сайхан байгалаас сайхан хүн төрнө”. Төрсөн хүү нь эргээд сайхан байгалаа унаган төрхөөр нь хамгаална, бас хөгжүүлнэ гэсэн санаа юм(МГЕЭ-I боть,184х).

Монголын геологи,ашигт малтмалын судалгааны эрчимтэй хөгжлийн үед геологичийн их армийн “Жанжин штаб”-ыг удирдаж байсан идэр залуу нас, олон улсын байгууллагад эх орноо төлөөлөн хоёронтоо томилогдон ажилласан эр дунд нас, эрдэм судлал, боловсруулалтын ажилд чөмгөө дундартал зүтгэсэн нас тогтсон үе,ухаан бодлоо ширгээж,удам судараа дэлгэж,захиас даалгавраа өгч буй өтөл буурал үе аль нь ч Жамбын Бямба хэмээх энэ Эрхмийн дүр төрхийг бүрэн төлөөлж чадахгүй мэтээ. Учир нь дээр дурьдсан мөчлөгүүд бол түүний геологич гэсэн нэг талыг л тодорхойлоод байна. Гэтэл бага насандаа тээж явсан уран зураач болох мөрөөдөл,түүнийг хожим нь монгол орныхоо байгалийн давтагдашгүй үзэсгэлэн,өнгө гэрлийг гэрэл зургийн хальснаа хэн хүнд байдаггүй буулгаж мөнхөлсөн олон мянган зураг, хэн хүнд байхааргүй хичээл зүтгэлээр цогцлон буй болгосон уран зургийн цуглуулга,хүн байгалийн нандин холбооны яруу сайхныг мэдэрсэн билэг авъяас, түүнийгээ хожим эссээ дурсамжиндаа буулгасан мөр бадаг, сайхан эх орноо, сэтгэлийнхээ мухарт хайрлаж, хүн ардаа жаргалтай чинээлэг амьдруулахсан хэмээсэн иргэний ухамсар,Эх орноороо бахархах сэтгэлээр аялал жуулчлалыг хөгжүүлэхийг чармайж ирсэн он жилүүд энэ бүхнийг нэвт сүлбэн дурайн харагдаж байна.Ингэж баймааж нь Жамбын Бямба хэмээх энэ Эрхмийн гэгээн дүр төрх бүтэн болох юм байна (МГЕЭ-I боть, 200х).

Алтан үеийн АХМАД ГЕОЛОГИЧИД-ын амьд төлөөлөл бодит дүр төрх болсон энэ Эрхэм гэж бүрэн дэмжиж байна.

8. Г.Жамсрандорж (МУ-ын “Зөвлөх геологич”, Геологи эрдэс судлалын ухааны доктор (PhD)

Ж.Бямба доктор Монголын тектоникийн тогтоцын талаар дагнасан судлагаа хийж байгаа энэ чиглэлийн Монгол улсын толгой эрдэмтэн. Тектоникийн чиглэлэр маш олон бүтээлийг монгол, орос хэлээр нийтлүүлсэн ОХУ-ын Байгалийн ШУ-ын Академийн жинхэнэ гишүүн. Ялангуяа плит тектоникийн онолын үндсэн дээр геодинамикийн байдлуудыг тогтоох судалгаа хийж байгаа нь ашигт малтмалын ордуудыг нээн илрүүлэх,тэдгээрийн байршлын зүй тогтлыг үнэн зөв орчин үеийн шинэ онолын үүднээс тайлах,эрэл хайгуулын ажлын чиглэлийг тодруулахад нэн ач холбогдолтой болж байгаа юм. Ашигт малтмалын ордуудын байршил,гарал үүслийг үүссэн геодинамикийн байдалтай нь шуудхолбон авч үзэж ашигтмалтмалын тодорхой төрлийн ордуудын байршлын зүй тогтлын талаар анхны том бүтээлээ тэрээр 2019,2024 онд нийтлэн хэвлүүлсэн нь геологичид, судлаачдын гүн талархалыг хүлээсэн юм. Террейн онолын үүднээс металлогены судлагааг хийж ордуудын байршил, гарал үүслийн шалтгааныг үнэн зөв тайлбарлахад зөрчил үүсч олон тайлбар гадна нь үлдээд байгаа энэ үед Ж.Бямбын ажил цаг үеэ олсон гэж үзэж байна. Цаашид Монгол улсын метал ашигт малтмалын байршлын зүй тогтлыг геодинамикийн үзэл баримтлалын үүднээс цоо шинээр хийх чухал суурь үндэслэл болсон байна.

Ж.Бямба зөвхөн геологич төдийгүй Монгол угсаатны оршин тогтноход урагийн бичигт ач холбогдол өгч Баянхонгор аймгийн Богд сумын бүх хүмүүсийн ургийн бичгийг 800 гаруй хуудас бүхий томоохон номонднэгтгэн гаргасан нь манай улсын хувьд энэ чиглэлээр хийсэн хамгийн том бүтээл болсон гэж Баянхонгорынхон үздэг.

9. А.Баасанжав (ГУУУЯамны нэгдүгээр орлогч сайдаар ажиллаж байсан, эдийн засгын ухааны доктор (PhD)

Шинжлэх ухааны доктор (Sc.D) Ж.Бямба гуай бол Монголын геологийн салбарын сэхээтнүүдийн анхдагчдын нэг мөнөөс мөн.

Салбарын хөгжлийн бодлого, менежмент, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, мэдээллийн технологи, хүний нөөцийн хөгжил, боловсрол, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт зэрэг үйл ажиллагааны бүхий л хэсэгт Ж.Бямба докторын оруулсан жинтэй хувь нэмэр их бий.

Ж.Бямба доктор бол миний багш. Оюутан бидэнд “Ашигт малтмалын эрэл” гэсэн хичээл зааж байсан. Их сургуулийг дөнгөж төгсөөд ажлын хуваарь авахаар Яаманд очивоос Геологийн хэлтсийн дарга Ж.Бямба гуай: -Геологич Ч.Дашням бид хоёроор Хөвсгөлийн Хатгалын орчимд барилгын материалын эрэл-хайгуулын ажил явуулах төсөл бичүүлж, Яамны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хуралдаанаар хамгаалуулан улмаар Хөвсгөлийн Геологийн удирдах газрын Хатгалын барилгын материалын хайгуулын ангид дагалдан инженерээр томилоод, ажил ид дундаа явж байсан намар нь Ж.Бямба дарга манай анги дээр ирж ажилтай танилцаж, бидэнд заавар зөвлөлгөө өгч, бидний амьдардаг майханд хоноод явсан даа. Дараа жилийн хавар Ж.Бямба дарга дагалдангийн шалгалт авч, намайг Улаанбаатарын Геологийн удирдах газарт барилгын материалын ангийн дарга, ерөнхий инженерээр дэвшүүлэн ажиллуулж билээ.

Тухайн үеийн ЭЗХТЗ хэмээх социалист орнуудын олон улсын байгууллагын төв аппаратад хоёр удаа томилогдон ажиллаж монголын геологит гадаадын хөрөнгө татан оруулах, геологийн судалгааг гишүүн орнуудын түвшинд хүртэл хөгжүүлэхэд бүхий л чиглэлээр нягт уялдуулан зохицуулах, хорших, хамтрах асуудлыг санаачлан боловсруулж хэрэгжүүлж байсныг нь заавал

хэлэх, дурсах ёстой гэж бодож байна.

Тэр л үед боловсруулсан хамтын ажиллагааны цогцолбор программд нэр заан орсон Тавантолгойн коксжих нүүрс, Цагаансуваргын зэс молибдений, Хөвсгөлийн фосфоритийн ордууд энэ зууны бүтээн байгуулалтын, эдийн засгийн хөгжлийн эх ундарга болж буйг дурдахад таатай сайхан байна.

Олон улсын геологийн экспедиц бол түүний санаачлан, үүсгэн байгуулсан бүтээл. Монголд анх удаа ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд бүгд үнэ төлбөргүйгээр хөрөнгөө оруулж, мэргэжилтнүүдээ ажиллуулж, монгол геологичидтой мөр зэрэгцэн ажиллаж маш ихийг хийж бүтээсэн ба анхны даргаар нь Ж.Бямба олон жил үр бүтээлтэй ажилласан юм.

Өнөөдөр геологийн салбартай холбоотой их, дээд сургуулиуд, аж ахуйн нэгжүүд, улс, аймаг, сумын удирдлагын аль ч шатны байгууллагын хананд нь өлгөөстэй Монголын геологийн, ашигт малтмалын, тектоникийн зэрэг олон сайхан зураг бүтээлүүд; номын сан, архив, ажилтнуудынх нь ширээ дээр өрөөстэй Монголын геологийн, геофизикийн, ашигт малтмалын, тектоникийн олон тооны ном, сурах бичиг, гарын авлагыг зохиосон, хамтран зохиосон хүмүүс, ерөнхий болон редакцийн гишүүдийн нь бүрэлдэхүүнд Ж.Бямба докторын нэр дурайж байгааг харахад бахархалтайяа.

Монголын ашигт малтмал, стратиграфын чулуун музей байгуулах агуу их ажлыг сэдэж, зүтгэж байгуулсан нь Ж.Бямба докторын нөр их хөдөлмөр, гавьяа бөгөөд тэрбээр гадаад орнуудын геологийн салбарын бүтэц зохион байгуулалтыг зэрэгцүүлэн нарийн судалсны үндсэн дээр 1990-ээд оны дундуур Японы геологийн албаны жишгээр “Монголын геологийн алба”-ыг анх байгуулж даргаар нь ажиллаж байлаа. Мөн Институтийн захирлаар ажиллаж байх үедээ геологчдийн орон сууцны хотхон байгуулах зураг төсөл, газрын зөвшөөрөл авах бичиг

баримтын төсөл боловсруулан өөрийн биеээр гардан хөөцөлдөн бүтээж байсан.

Ер нь хийсэн ажил, бичсэн зохиосон ном, зураг, туурвилууд, эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв, нэвтрүүлсэн бүтээлүүдийн тоо, чанарыг дэнслээд үзвэл доктор, профессор Ж.Бямба гуай бол Монголын геологийн хөгжилд, геологийн шинжлэх ухааны хөгжилдүгйгсгэх аргагүй, даравч дардайж, булавч бултайх хувь нэмэр оруулсан сод мэргэдийн нэг билээ. Гэтэл ганцхан бүтээлд нь Төрийн соёрхол хүртээснээр ам хааж байгаад ихэд харамсдагдаа.

Тал бүрийн авьяас чадвартай хүмүүс байдгийн нэг нь Ж.Бямба гуай. Тэрээр мэргэжлийн түвшинд уран зураг зурна, уран зохиол бичнэ, дизайн хийнэ. Бүсгүй хүний гараас хөтлөөд хөнгөнөөр эргэлдэн бүжихийг нь харсан хэн боловч түүний авьяаст, намбанд атаархана даа. Ж.Бямба доктор бол маш цэвэрч цэмцгэр хүн. Үнэтэй цайтай хувцас өмсөнө. Биеэ авч яваа байдлыг нь дуурайх гэж ихэд хичээдэг байлаа.

Төрсөн нутгийнхаа хүн ардын буюу Баянхонгор аймгийн Богд сумын бүх хүний угийн бичгийг хөтөлсөн хүн бол Ж.Бямба доктор. Сумаараа угийн бичигтэй өөр сум Монголд байхгүй байх. Баянхонгор аймгаас төрөн гарсан шинжлэх ухааны докторуудын дийлэнх нь Богд сумынх. Ийм аугаа авьяастнуудтай нь мөнх цаст Богдуул хайрханы хувилгаан чанар, ид шид, илбэ ухааны хүч байхаа гэж бодном.

10. Т.Ганбаатар (МУ-ын “Зөвлөх инженер”, Ахмад хүндэт геологич)

Ж.Бямба доктор нь “Монгол суурь бүтээлийн ерөнхий эрхлэгч” ба хамгийн олон бүтээл туурвисан “ эрдэмтэн-геологич, 3 улсын геологийн салбарын шагналтан, ОУГЭ-ийн болон ҮГА-ны анхны дарга (ЧСЧХ ном 578-579х) гэсэн олон анхдагчийн тодотголтой хүн. Бидний нилээд олон хамтын бүтээл бий. Ж.Бямба гуай бол хийж бүтээхийн төлөө төрсөн юм шиг уран

бүтээлч, оюунлаг, бүх талаараа өв тэгш хүн

11. И.Логшир /ГУУСАхХолбооны “Хүндэт тэргүүн”, “Ахмад хүндэт геологич”/

-Би Бямба/ ScD/ докторыг сайн мэднээ. Төрийн дээд шагнал авах ёстой салбартаа үнэнч одоо ч үүрэг гүйцэтгэж байгаа цөөхөн хүний нэгээ. Сугаржав тэргүүн олон талаас нь дорвитой сайн судалгаа хийсэн нь: “Ж.Бямба нь плиттектоникийн чиглэлийн судалгаа түлхүү хийж, “далайн геологи” судладаг эрдэмтэн —геологичоос гадна уран зураг цуглуулагч, урлаг сонирхон судлаач, гэрэл зураг сонирхогч, Асралтхайрхан, Мөнххайрхан уулын оройгоос Монголоо тольдсон уулчин, аливаа шинэ зүйлийг санаачлан түүчээлэгч зэрэг олон талын мэдлэгтэй, зохион байгуулах авьяас чадвартай, эрдэм судлалын ажил бүтээлийг ундруулагч эрдэмтэн-геологич юм” гэдэгтэй санал нэг байна.

Дүгнэлт

Ж.Бямба нь өөрийн ухамсарт бүхий л амьдралаа Монголын геологийн салбарыг хөгжүүлэхийн төлөө зориулсан бөгөөд түүний сүүлийн үед баримталж байгаа орчин үеийн Хавтан(плит)-гийн тектоникийн онол дээр суурилсан “Геодинамикийн шинжлэх ухааны үзэл баримтлал” нь ашигт малтмалын зүй тогтлыг илрүүлэхэд чухал ач холбогдолоо өгч зэс-алт, зэс-молибдений Эрдэнэтийн овоо, Оюутолгой, Хармагтай болон Дорнод Монголын хайлуур жонш, нүүрс, уран-полиметал, цагаан тугалга-вольфрамын гэх мэт голлох ордуудын ба бусад ашигт малтмалуудын зүй тогтлыг илүү шинжлэх ухааны онолын үндэслэлтэй болгож цаашид аливаа нутаг дэвсгэрт эрдэс баялгийг эрж хайхад онолын үндэс суурь, шинэ үзэл баримтлал болж байгаа зэрэгээр Монголын геологийн салбарыг дэлхийн тавцанд гаргах эрхэм үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан “Эрдэмтэн-геологич” билээ.

Ашигласан хэвлэл, зарим үгийн товчлол

Ж.Сумъяа, Н.Өлзийбат, И.Логшир нарын "Мянганы босго алхсан Монгол геологичид". 2009 он.-МБАМГ

Д.Санжаадорж нарын "Монголын геологийн есөн эрхэм". 2014 он.- МГЕЭ

Ө.Жамьяндоржийн "Чулуу судлаач чухал хүмүүс". 2019 он.-ЧСЧХ

Ч.Хурц "Хурц амьдрал" I, II, III боть —Хурц амьдрал

Ж.Бямба "Хоёр үнэний хооронд" 3 боть ном.-ХҮХ

Ж.Бямбын цол хэргэмийн тухайд:

- 1959-1965 онд Москва хотод геологи-хайгуулын дээд сургуульд суралцаж уулын инженер геологчийн мэргэжилтэй болсон.
- 1972 онд "Хойд Монголын рифей-кембрийн структур-фацын бүсүүд ба тэдгээрийн фосфорит агууламж" сэдвээр геологи-минералогийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан.

- 1991 онд "Монголын хожуу протерозой-түрүү палеозойн тектоникийн хөгжил ба эртний фосфорит үүссэн геологийн нөхцөл" сэдвээр геологи-минералогийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан.

- 1994 онд Японд Жайка-гийн шугамаар геологийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлсэн.

- 1998 онд МУ-ын дэд профессор(№98879)

- 2001 онд МУ-ын Үндэсний Шинжлэх ухааны академийн гишүүн

- 2011.11.29-нд МУ-ын ШУТИС-ийн "Хүндэт профессор"

- 2019.01.30-нд Оросын холбооны улсын Байгалийн Шинжлэх ухааны академийн гадаад дахь гишүүн (№МРО122/5)-ээр тус тус өргөмжлөгджээ.

Жич. Илтгэлийг нилээд хураангуйлж цэгцлэн тавих болно.